

СУМ ДУНДЫН ОЙН АНГИЙН
ӨНГӨРСӨН 7 ХОНОГТ ХИЙСЭН
АЖЛЫН МЭДЭЭЛЭЛ, СУДАЛГАА

2018.04.12

№	7 хоногийн ажлын товч мэдээлэл	Дараагийн 7 хоногт шийдвэрлэвэл зохих асуудал	Бусад асуудал
1	Өнгөрсөн 2017 онд манай аймгийн ойн сан бүхий газруудад Ой зохион байгуулалтыг хийж гүйцэтгэсэн ажлын талаар БОАЖЯамны харьяа Ойн судалгаа, хөгжлийн төвийн Ойн нөөц, ашиглалтын албаны дарга Х. Мичид тэргүүтэй хүмүүс ирж 2-р зөвлөгөөнийг БОАЖГазар, МАНУТХГХЗахиргаа болон Сум дундын ойн ангийн холбогдох хүмүүстэй хамт хийж танилцууллаа.		
2	Байгууллагын 2018 оны 1-р улиралд хийж гүйцэтгэсэн ажлын тайланг бичиж БОАЖЯамны харьяа Ойн судалгаа, хөгжлийн төв, аймгийн ЗДТГазар болон БОАЖГазруудад тус тус хүргүүллээ.		
3	Увс, Сэлэнгэ аймгуудаас ирсэн гэрийн модыг эрхийн бичиггүйгээр ард иргэдэд худалдаж байна гэсэн мэдээллийн дагуу Ногооннуур суманд Цагдаагийн газар, БОАЖГазруудтай хамтран газар дээр нь шалгахад ямар нэгэн зөрчилгүй байсаныг тогтоосон болно.		
4	Хаврын Бүх нийтээр мод тарих өдрөөр мод тарих газрыг сонгож бэлтгэл ажлыг хангуулах талаар Өлгий сумын Засаг даргад албан бичиг хүргүүллээ.		

СУМ ДУНДЫН ОЙН АНГИ